



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/2021

Номгон


М.Уранцэцэг Ц.Цогтбаатар нарт хүндэтгэл
үзүүлж мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а". Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 90 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтын нийтлэг журам" ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Токио- 2020 олимпын наадмын Жудо бөхийн тэмцээнд Монгол улсаа төлөөлөн амжилттай оролцож Хүрэл медаль хүртсэн Баянхонгор аймгийн тамирчин М.Уранцэцэг Ц.Цогтбаатар нарт хүндэтгэл үзүүлж мөнгөн шагнал олгосугай.

2.Олимпын Хүрэл медальт М.Уранцэцэг Ц.Цогтбаатар нарт хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай 60.000.000 /жаран сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэргэжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210165